



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Ерөнхий сайдын албан даалгаврыг
хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 01 дүгээр, 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 болон 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан Ерөнхий сайдын албан даалгаврын холбогдох заалтын хэрэгжилтийг хангах ажлыг өөрийн байгууллага, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг сар бүрийн сүүлийн 7 хоногийн Лхагва гарагт Захиргаа, удирдлагын хэлтэст ирүүлж байхыг хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн, сар бүрийн сүүлийн 7 хоногийн Баасан гарагт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байхыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003239

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/143 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАРЫН 2025 ОНЫ 01 БОЛОН 04 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэслэл бүхий шийдвэр

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтэцмжийг сайжруулах тухай" 01 дүгээр албан даалгавар;
2. Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэл (хэлэлцсэн асуудал "9.1.Засгийн газрын агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн чиг үүрэг, бүтэц, орон тоог оновчтой болгох талаар авах зарим арга хэмжээний тухай");
3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавар.

Д/д	Албан даалгавар, тэмдэглэлийн заалтын дугаар, өгсөн үүрэг даалгаврын агуулга	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах үүрэг бүхий хэлтэс	Хариуцан хэрэгжүүлж, тайлагнах тухайн хэлтсийн ажилтан	Үүрэг даалгаварт удирдлагаас өгөх чиглэл, тэмдэглэл
Нэг. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр албан даалгавар:					
1	1.Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй, тогтвортой бий зарчмыг хангаж ажиллах хүрээнд: 1.1 шинжлэх ухааны судалгаа нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах;	Жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ ТӨБАХ-ийн дарга Д.Нарангэрэл ТӨХШХ-ийн дарга Ц.Түвшинзава ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа	ЗУХ, Г.Туул ТӨУЗХ, Б.Билгүтэ ТӨБАХ: П.Уранмандах ТӨХШХ: Э.Ганчимэг ХЗЗХ: Ө.Саранцацэг	- Гарч байгаа шийдвэрт акаарч, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх. - Хэлтэс бүр хэрэгжилтийг тайлагнаж, нэгтгүүлэх.
2	1.2 төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайлыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай	Жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ЗУХ, Н.Дагиймаа ТӨУЗХ, Д.Дариймаа	- ЗУХ-ээс байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг хангуулах.

	хэрэгжүүлж, төрийн албан хэргийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах.					<ul style="list-style-type: none"> - ТӨУЗХ-ээс харьяа хуулийн этгээдэд хэрэгжилтийг хангуулах. - ЗУХ-ээс байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг хангуулах. - ТӨУЗХ-ээс харьяа хуулийн этгээдэд хэрэгжилтийг хангуулах.
3	1.3 яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөрхүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шалттай цөөлөх.	Жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ЗУХ: Н.Дагиймаа, Д.Отгонтуяа ТӨУЗХ: Г.Нямдаваа	<ul style="list-style-type: none"> - ЗУХ-ээс байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг хангуулах. - ТӨУЗХ-ээс харьяа хуулийн этгээдэд хэрэгжилтийг хангуулах. 	
4	1.4 салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлог нийцсэн инновац, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн шийдвэр гэрэлтэд хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах.	ҮШ/10	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ЗУХ: Г.Туул, Н.Дагиймаа, Т.Мөнхбаяр ТӨУЗХ: Г.Нямдаваа	<ul style="list-style-type: none"> - ЗУХ-ээс байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг хангуулах. - ТӨУЗХ-ээс харьяа хуулийн этгээдэд хэрэгжилтийг хангуулах. 	
5	1.5 улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах.	Жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ЗУХ: Н.Дагиймаа, Д.Цэрэнлхам ТӨУЗХ: Г.Нямдаваа	<ul style="list-style-type: none"> - ЗУХ-ээс байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг хангуулах. - ТӨУЗХ-ээс харьяа хуулийн этгээдэд хэрэгжилтийг хангуулах. 	
6	1.6 эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	1X/20	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: О.Ишханд	<ul style="list-style-type: none"> - Судалж холбогдох арга хэмжээний санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах. - харьяа хуулийн этгээдэд хэрэгжилтийг хангуулах - холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх 	
7	1.7 салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусуулан, шуурхай шийдвэрлэх.	ҮШ/20	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ТӨУЗХ: Б.Амарбаясгалан ЗУХ: Т.Мөнхбаяр	<ul style="list-style-type: none"> - Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, тайлагнах. 	

8	1.8 Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах	Жилдээ	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ ТӨБАХ-ийн дарга Д.Нарангэрэл ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа	ТӨУЗХ В.Дарханбаатар ТӨБАХ ХЗЗХ: Ө.Саранцэцэг ЗУХ: Г.Туул ХЗЗХ: Э.Уянга	- Үйл ажиллагаандаа анхаарч ажиллах. - Хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллах; - Хэлтэс, албан хаагчдад мөрдүүлэх
9	2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: 2.1 Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;	Жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд, ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа		
10	2.2 төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	IX/15	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ТӨБАХ-ийн дарга бөгөөд нууц хамгаалах ажилтан Д.Нарангэрэл	- Хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллах.
11	2.3 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох.	X/30	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ Б.Амарбаясгалан	- Хяналт тавих ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах.
12	2.4 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Аалигын зэрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, аалига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх;	XI/01	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨБЗГ-ын Ёс зүйн дэд хороо ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ЗУХ: Х.Энхчимэг Н.Дагиймаа ТӨУЗХ: Г.Нямдаваа	- Хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллах, үр дүнг тайлагнах - ТӨБЗГ-ын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, - ТӨУЗХ-ээс харьяа төрийн өмнөт хуулийн этгээдийг мэдээлэл, чиглэлээр хангаж, хяналт тавьж ажиллах.
13	2.5 төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт	жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ: Н.Дагиймаа	- Хэрэгжилтийг хангахад анхаарах.

	үзүүлэхгүй байх.					
14	2.6.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцож ажиллах.	ҮШШ20	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Д.Дариймаа	- Харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллах, үр дүнг тооцож, тайлагнах.	
15	3.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх асуудлын хүрээнд хямаарах асуудлыг бүрэн хариуцаж, гэрсэн шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх.	жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ ТӨБАХ-ийн дарга Д.Нарангэрэл ТӨХШХ-ийн дарга Ц.Түвшинзаяа ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа	ЗУХ: Д.Цэрэнлхам ТӨУЗХ: Г.Нямдаваа ТӨБАХ: П.Уранмандах ТӨХШХ: Э.Ганчимэг ХЗЗХ: Х.Нарангарав	- Засгийн газрын шийдвэрийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнах ажлын хяналтыг сайжруулах. - Хэлтэс бүр хэрэгжилтийг тайлагнаж, нэгтгүүлэх.	
Хоёр. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгавар:						
1	1.1."Цомхон, чадварлаг, бүтээмжтэй төр"-ийг төлөвшүүлэх төрийн албаны шинэтгэлийг эхлүүлж, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод.	жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ: Г.Туул, Н.Дагиймаа	- Төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах, - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлийг барих.	
2	1.2.Төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог цэрцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад.	жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ: Н.Дагиймаа	- Хэрэгжилтийг хангаж ажиллах, - Хэлтсийн дарга нарт болон албан хаагчдад ойлголт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах.	

3	1.3.Иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад.	жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд ТӨБЗГ-ын Ёс зүйн дэд хоргоо	ЗУХ Н Дагиймаа	<ul style="list-style-type: none"> - Хэрэгжилтийг хангаж ажиллах; - албан хаагчдад ойлголт, мэдээлэл өгөх, сургалт, соён гэгээрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулах.
4	1.5.Төрийн байгууллагуудын ажиллах байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, систем хоорондын залгамж, уялдаа холбоог ханган, давхардлыг арилгах, төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй цахим үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх асуудлыг судалж санал боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайд Э.Батшугарт,	жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ Т Мөнхбаяр	<ul style="list-style-type: none"> - Анхааралдаа авч, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх.
5	1.6.Чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд мэргэжлийн үнэлгээ буюу аттестатчиллыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацолтод,	Тухай бүрд	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ Н Дагиймаа	<ul style="list-style-type: none"> - ЗГХЭГ, ТАЭ-өөс өгсөн чиглэл, удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлж уг ажилд бэлтгэх арга хэмжээг авах; - Үнэлгээнд албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулалтаар хангах.
6	1.7.Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг	жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ Н Дагиймаа	<ul style="list-style-type: none"> - Анхааралдаа авч, үйл ажиллагаандаа хэрэгжилтийг хангаж ажиллах.

7	Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт; 2.7 төрийн бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор "Цахимаар түрүүнд" ("Digital first") бодлогын төслийг боловсруулан батлуулж, төрийн байгуулгалуудын цахим шилжилтийг уялдуулах ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор эхлүүлэх.	IX/20	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ: Т.Мөнхбаяр	- Анхааралдаа авч, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хүрээнд цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах, - Уг асуудлаар Эдийн засаг, хөгжлийн яамнаас өгөх чиглэлийг хэрэгжүүлж ажиллахад анхаарч, зохион байгуулалтаар хангах.
8	5.1 Засгийн газрын агентлаг, бусад байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор арилгаж, бүтэц зохион байгуулалтыг шинээр тогтоох.	YIII/30	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ: Х.Энхчимэг	- Хэрэгжилтийг хангаж, ТӨБЗГ-ын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн саналыг боловсруулж, ЗГХЭГ-т хургуулж шийдвэрлүүлэх
9	5.2 төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын үр ашиг, засаглалыг сайжруулах зорилгоор бүтэц бүрэлдэхүүнийг оновчтой тогтоох, үр ашгийг зардлыг бууруулах, техник, технологийн шинэчлэлтийг эрчимжүүлж, бизнесийн үйл ажиллагааны ашгийг нэмэгдүүлэх, шинээр хэрэгжих төслүүдийг үр ашиг, техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, санхүүгийн тооцооллын зааварчлалын дагуу үнэлэн, эрэмбэлж, төслийн компаниудыг нээлтээ, нийлүүлэх, нээлттэй компани болгох замаар өөрчлөн байгуулах арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор авч, төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоог бууруулах.	YIII/30	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Д.Дариймаа	- Засгийн газрын 100 хоногийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээ авч, үр дүнг тооцон тайлагнах.
10	5.3 Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах	IX/05	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Д.Дариймаа	- Хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг тооцож, тайлагнах.

	<p>үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоослын төслийг боловсруулж, 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор өргөн мэдүүлэх.</p>			
11	<p>5.4 төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийн үйл ажиллагааг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор эхлүүлэх.</p>	<p>ҮИШ/25</p>	<p>ЗУХ-ийн дарга Н Ганболд ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ ТӨБАХ-ийн дарга Д.Нарангэрэл ТӨХШХ-ийн дарга Ц.Түвшинзаяа ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа</p>	<p>ЗУХ: Т.Мөнхбаяр ТӨУЗХ: А.Молор ТӨБАХ: Б.Мөнхбаяр ТӨХШХ: А.Алтаншагай ХЗЗХ: Б.Янжинлхам</p>
12	<p>5.5 төрийн өмчит компаниудад олон улсын стандартын дагуу эрсдэлд суурилсан дотоод аудит, хөндлөнгүйн чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийлгэх ажлыг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор эхлүүлэх.</p>	<p>ҮИШ/30, Жилдээ</p>	<p>ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ</p>	<p>- Хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг тосгож, тайлагнах. - ТӨБЗГ-ын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 313 дугаар тогтоогоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг үнэлэх аргачлал"-ыг хэрэгжүүлж, төрийн өмчит компаниудад үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэх.</p>
13	<p>5.6 Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн менежментийг салбар дундын уялдаа, зохицуулалтаар хангах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, дүнг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.</p>	<p>ҮИШ/30</p>	<p>ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ</p>	<p>- ТӨБЗГ-аас тусгах холбогдох саналыг ЗГХЗГ-т өгөх арга хэмжээ авах.</p>

14	5.13.терийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын албан тасалгааны ашиглалтын талбайн хэмжээг нэгдсэн стандарттай болгох санал боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор танилцуулах.	IX/25	ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа ТӨБАХ-ийн дарга Д.Нарангэрэл ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ХЗЗХ. Б.Янжинпхам ТӨБАХ. Д.Батболд, Л.Гэрэлмаа ТӨУЗХ. Д.Одмаа, Г.Дэлгэрмаа	- Хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг тооцож, тайлагнах.
15	5.17.өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах мэдээллийн нэгдсэн санг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор бий болгож, системийг хөгжүүлэх арга хэмжээ авах.	Тухай бүрд	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ. Н.Дагиймаа, Д.Цэрэнпхам	- Анхааралдаа авч, шаардлагатай арга хэмжээг авах; - Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийн нээлттэй байдлыг хангах.
16	9.6.Үндэсний геологийн албанд Ашигт малтмал, газрын тосны агентлагаас холбогдох чиг үүргийг, Газар зүй, геологийн хүрээлэнгээс геологийн секторыг, Одон орон, геофизикийн хүрээлэнгээс геофизикийн секторыг болон Геологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, "Геологийн судалгаа, шинжилгээний төв" ТӨҮГ-ыг тус тус нэлтэх, геологи, эрдэс баялгийн судалгааг эрчимжүүлэх цогц арга хэмжээний санал боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх.	IX/25	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ. Д.Дариймаа	- "Геологийн судалгаа, шинжилгээний төв" ТӨҮГ-ыг Үндэсний геологийн албанд нэлтэхтэй холбоотой асуудлаар санал боловсруулж, ЗГХЗГ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авах.
17	13.1.Капитал, Чингис хаан банкуудад байршуулаад авч чадаагүй нийгмийн даатгалын сангийн чөлөөт хөрөнгийг эргүүлж авах талаар хуулийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.	IX/30	ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа ТӨБАХ-ийн дарга Д.Нарангэрэл	ХЗЗХ. Х.Нарангарав ТӨБАХ. Л.Гэрэлмаа	- ТӨБЗГ-г хамааралтай асуудлаар Гэр бул, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллах, Дэмжлэг үзүүлэх.

18	14.1. далайн хамгийн ойр босомтуудтай холбогдох Монгол, Орос, Хятад гурван улсыг холбосон Эрэнцав-Бичигт чиглэлийн Зүүн босоо төмөр замыг төр, хувийн хэршлийн түншлэлээр барьж байгуулах ажлыг эрчимжүүлэх.	Тухай бүр	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Б.Амарбаясгалан	- Уг асуудлаар Зам, тээврийн яамттай хамтран ажиллаж, чиг үүргийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.
19	14.2. Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод босомтын хил дамнансан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэвийн, тасралтгүй үргэлжлүүлэхэд онцгойлон анхаарч, цаашид Шивэхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатаг, Ханги-Мандал босомтуудыг төмөр замаар холбох асуудлаар хятадын талтай хийх яриа, хэлэлцээг "Эрдэс баалаг, эрчим хүч дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан зөвлөл"-өөр дамжуулан эрчимжүүлэх.	Тухай бүр	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Б.Амарбаясгалан	- Уг асуудлаар Зам, тээврийн яамттай хамтран ажиллаж, чиг үүргийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.
20	14.4. "Монголын төмөр зам" ТӨХК, Чайна энержи компани хооронд байгуулсан нүүрс тээвэргэлтийн гэрээний дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтод зориулсан шинэ гарц байгуулах, 1.0 сая.тн. ачав тээвэрлэх ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор эхлүүлэх.	Тухай бүр	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Б.Амарбаясгалан	- Уг асуудлаар Зам, тээврийн яамттай хамтран ажиллаж, чиг үүргийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.
21	14.5. олон улсын нислэгийн чиглэл, давтамжийн тоо өсөж, зорчигч, жуулчдын урсгал жил бүр нэмэгдэж байгаагаас шалтгаалан үүссэн "Чингис хаан" Олон улсын нисэх онгоцны буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагыг харгалаан тус нисэх буудлыг өргөтгөх судалгаа, тооцоог 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор бэлэн болгох.	ҮНШ/30	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Д.Дариймаа, Д.Одмаа	- Уг асуудлаар Зам, тээврийн яамттай хамтран ажиллаж, чиг үүргийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.
22	14.7. Багахангай-Хөшигийн хөндийн салбар төмөр замыг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор багтаан ашиглалтад оруулах.	Х/31	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: Б.Амарбаясгалан	- Уг асуудлаар Зам, тээврийн яамттай хамтран ажиллаж, чиг үүргийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.

23	16.4 улсын хэмжээнд гадаад харенгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Ногоон нуур 1028 айл", "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэн барих (Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймаг)", "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих", "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх", "Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах" төслүүдийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ашиглалтад оруулах.	IX/30	ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ТӨУЗХ: А.Молор	- Уг асуудлаар Хот байгуулалт, арилга, орон сууцруулалтын яамтай хамтран ажиллах, чиг үүргийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах.
24	18.6.терийн байгууллагын албан бичгийг иргэд цахимгаар, эсхүл цавсаар хүлээн авах боломж, сонголтыг бий болгох.	Жилдээ	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ: Т.Мөнхбаяр	- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас бий болгох уг ажлыг хэрэгжүүлэхэд анхаарч, холбогдох арга хэмжээ авч ажиллах.
25	19.8 "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа "Эрдэнэт медилас эмнэлэг" хязгаарлагдмал хармуцлагатай компанийг "Хойд Бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв" эмнэлэг болгон өөрчлөн зохион байгуулж, Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэх асуудлыг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.	Үйлдвэр	ТӨБАХ-ийн дарга Д.Нарангэрэл ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа	ТӨБАХ: М.Баярмаа ХЗЗХ: Ө.Саранцэцэг	- ТӨБЗГ-ын даргын 2025 оны А40 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлтийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, уг асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хууль, эрх зүйн хүрээнд хамтран ажиллах.
26	Албан даалгаврын хансралтын 2 дахь заалт: Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон Нийтийн өмчийн хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах.	Тухай бүрд	ХЗЗХ-ийн дарга Д.Дэлгэрмаа ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ	ХЗЗХ: Ө.Саранцэцэг ТӨУЗХ: В.Дарханбаатар, Ц.Шинэхүү	- Ажлын хэсэгт шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллах.
Гурав. Засгийн газрын 2025 оны 04 хуралдааны тэмдэглэл (9.1 дэх асуудал):					
1	1.Засгийн газрын агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газар компанийн чиг үүрэг, бүтэц,	Үйлдвэр	ЗУХ-ийн дарга Н.Ганболд	ЗУХ: Х.Энхчимэг ТӨУЗХ:	- ЗУХ-ээс ТӨБЗГ-ын стратеги, бүтцийн өөрчлөлтийн

<p>орон тоог оновчтой тогтоож, төрийн байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, хүнд суртлыг багасгаж, шат дамжлагыг цөөлөх, өргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох чиглэлээр:</p> <p>1.1 эрхэлсэн чиг үүрэг, харьяа салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын агентлаг, төв, нэгж, улсын үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн чиг үүрэг, үйл ажиллагааны үр ашиг, үндэслэл, хэрэгцээ, шаардлагад дун шинжилгээ хийж, нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтэц, орон тоог оновчтой тогтоох, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэн гүйцэтгүүлэх саналыг холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах</p>	<p>ТӨУЗХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ</p>	<p>В.Дарханбаатар, Ц.Шинэхүү</p>	<p>хөтөлбөрийг энэ тэмдэглэлийн 1.2 дахь заалтад заасан чиглэлийн дагуу боловсруулж, саналын төслийг ЗГХЭГ-т хүргүүлэх,</p> <p>- ТӨУЗХ-ээс төрийн өмчит үйлдвэрийн газар, компанитай холбоотой уг тэмдэглэлд заасан асуудлыг судлан, санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх, тэмдэглэлийн хэрэгжилт, үр дүнг тайлагнах.</p>
---	--------------------------------------	--------------------------------------	---

Ерөнхий сайдын өгсөн холбогдох 42 үүрэг даалгаврыг төлөвлөгөөнд тусгав.